



**ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2022 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/163

Улаанбаатар хот

Эмнэлгийн төлбөртэй тусламж үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ
үзүүлэх жагсаалт, журам шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалт, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь заалт, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49/А/118 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаар тушаал, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоол, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3.2.1 дэх заалт үндэслэн ТУШААХ нь:

1. Тус эмнэлгийн төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний журмыг нэгдүгээр, иргэн өөрийн хүсэлтээр төлбөртэй тусламж, үйлчилгээ авах зөвшөөрлийн маягыг хоёрдугаар, эмнэлгийн төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг гуравдугаар, эмчилгээний тасагт ажиллуулах төлбөртэй орны тоо, үнийн жишгийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар ханган, хэрэгжүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээ хариуцсан дэд захирал (Р.Гантуяа), Санхүү бүртгэлийн албаны дарга (Ц.Энхбаяр) нарт тус тус даалгасугай.
3. Энэхүү тушаалыг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, холбогдох хууль журмын хүрээнд сахилга, хариуцлагатай хандан, гүйцэтгэлийг ханган ажиллахыг нийт тасгийн эрхлэгч, албадын дарга нарт тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанар, аюулгүй байдлын албаны дарга (Б.Бат-Оргил), дотоод аудитор (Ц.Сугармаа) нарт тус тус даалгасугай.
5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гэмтэл согог судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/315 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Э.ГАЛБАДРАХ

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн
Ерөнхий захирлын 2022 оны 11 сарын 29-ны
... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс үзүүлэх улсын төсвөөс хариуцах болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчдийн хүсэлтийн дагуу нэмэлтээр үзүүлэх, эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэнд төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлснээс бий болсон орлогыг зарцуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Иргэнээс энэхүү тушаалын хавсралтад заасан төлбөртэй тусламж үйлчилгээний төлбөрийг авахдаа улсын төсвийн болон эрүүл мэндийн даатгалын сангаас тухайн тусламж үйлчилгээний төлбөрийг санхүүжүүлэхгүй байгаа шалтгааныг тайлбарлаж, иргэн зөвшөөрсний үндсэн дээр өөрийн хүсэлтээр төлбөртэй тусламж үйлчилгээ авах зөвшөөрлийн маягтыг бичүүлэн төлбөр авна.

1.3. Төлбөртэй тусламж үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ гэдэгт Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49/A/118 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны A/216 дугаар тушаалуудыг хамруулан ойлгоно.

1.4. Энэхүү тушаалын хоёр ба гуравдугаар хавсралт болон төлбөрт үйлчилгээний жагсаалтад ороогүй тусламж үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагын дарга батлахгүй бөгөөд зайлшгүй шаардлагаар шинэ технологи, хөрөнгө оруулалтаар хийгдсэн тусламж үйлчилгээ нэмэгдэх бол Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад холбогдох мэдээллийг албан бичгээр ирүүлж, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлүүлнэ.

Хоёр. Төлбөртэй болон нэмэлт тусламж үйлчилгээг зохион байгуулах

2.1. Төлбөртэй үйлчилгээний төрөл, ажиллах эмч, мэргэжилтний тусламж, үйлчилгээ үзүүлэх цагийн хуваарийг Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан дэд захирал, Амбулаторийн эрхлэгч, ЭМТҮЧАБАлба зөвшилцөн санал болгосныг үндэслэн Ерөнхий захирлын тушаалаар батална.

2.2. Үйлчлүүлэгчдийн хүсэлтээр тэдний хүлээгдэл, чирэгдлийг бууруулах зорилгоор Амбулаторийн үзлэгийг ажлын бус цагаар нэмэлт тусламж үйлчилгээ үзүүлэх ба ажиллах эмч, мэргэжилтний хуваарийг Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан дэд захирал, Амбулаторийн эрхлэгч, ЭМТҮЧАБАлба зөвшилцөн санал болгосныг үндэслэн Ерөнхий захирлын тушаалаар батална.

2.3. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орсон тусламж үйлчилгээг эрүүл мэндийн даатгалгүй иргэнд үзүүлэх тохиолдолд эрүүл мэндийн даатгалд даатгуулахыг санал болгож, хэрэв татгалзсан тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу баталсан төлбөрийн хэмжээг баримтлан төлбөртэй тусламж үйлчилгээг үзүүлнэ.

2.4. Эмнэлгийн нийт батлагдсан орны 15 хувиас хэтрэхгүйгээр тав тух хангасан төлбөртэй өрөөг ажиллуулж болох ба тасгуудад жигд хуваарилж, үйлчлүүлэгчдэд сонголтыг бий болгож, зохицуулалтыг хийнэ.

2.5. Тус эмнэлгийн эмч, ажилчид төлбөртэй өрөөнд хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд ажилтны эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг дэмжих зорилгоор төлбөрийн 50 хувиар хөнгөлөлт үзүүлж болно.

2.6. Тоноглогдсон автомашинаар үзүүлэх үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтээр эмч, сувилагч байлцуулан тусламж үйлчилгээ үзүүлж болно.

2.7. Тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх жолооч, үйлчлүүлэгч хүсвэл өвчтөнийг тээвэрлэхэд байлцах эмч, сувилагчийн ажиллах хуваарийг Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан дэд захирал батална.

2.8. Үйлчлүүлэгч төлбөрөө төлснөөр захиалга баталгаажих бөгөөд цахим бүртгэлийн ажилтан тус үйлчилгээг үзүүлэх жолоочид тээвэрлэлтийн мэдээлэл /тээвэрлүүлэх газар, цаг, тээвэрлүүлэх хүний нэр, тоо, явах км, эмч, сувилагчтай эсэх гэх мэт/-ийг өгөх бөгөөд жолооч тус мэдээллийн дагуу, төлбөрийн баримтыг үндэслэн тээвэрлэлт хийх ба тээвэрлэлтийн бүртгэлийн дэвтэр буюу журналд бичилт хийн, Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан дэд захиралд танилцуулна.

2.9 Алсын дуудлагад үйлчлүүлэгчийн хүсэлтээр нисдэг тэрэг болон онгоцоор тусламж үйлчилгээ үзүүлэхэд эмч, сувилагч шаардлагатай тохиолдолд энэхүү журмаар тогтоосон төлбөрийг өөрөө төлнө.

2.10 дахь заалтыг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/117 тоот тушаалын 1-р хавсралтын 2.7 дахь заалтад заасны дагуу гадаадын иргэнд үзүүлсэн эмчилгээний төлбөрийг 2 дахин нэмэгдүүлж төлбөртэй тусламж үйлчилгээг үзүүлнэ.

2.11. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж үйлчилгээний өртгийн тооцоололд ороогүй, ЭМДЕГ болон эрүүл мэндийн байгууллага хооронд байгуулсан гэрээнд тусгайлан заагдсан, иргэний хүсэлтийн дагуу үзүүлсэн тусламж үйлчилгээний төлбөрийг 100 хувь иргэн өөрөө төлнө.

Гурав. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлого бүрдүүлэлт, зарцуулалтын талаар

3.1. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлого, зарцуулалтыг бодитой төлөвлөж, жил бүрийн төсөвтөө тусгаж Эрүүл мэндийн тухай хууль болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасан Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын эрх үүргийн хүрээнд захиран зарцуулна.

3.2. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлогыг тухайн үйлчилгээг үзүүлэхэд оролцсон эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, засвар, үйлчилгээ хийхтэй холбоотой гарах зардалд байгууллагын ерөнхий захирлын гаргасан журмын дагуу хуваарилж зарцуулна.

3.3. Тухайн жилийн төсөвт тусгагдаагүй, шинээр бий болсон үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг Төсвийн тухай хуулийн 46.2-т заасан журмын дагуу зарцуулж, тайлагнана.

3.4. Үйлчлүүлэгч байгууллагын кассаар эсвэл пос машинаар төлбөр төлөх ба төлбөрийг төрийн сан дахь 100 9000 200 12 тоот дансанд төвлөрүүлж, үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэнэ.

3.5. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээнээс олсон орлогыг эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэлийн болон санхүүгийн программд бүртгэж, тайлагнаж ажиллана.

3.6. Иргэнд төлбөр төлсөн баримтыг (и-баримт) заавал олгох бөгөөд уг баримтад эрүүл мэндийн байгууллагын нэр, үйлчлүүлэгчид үзүүлсэн төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний нэр, төрөл, төлбөл зохих нийт болон үйлчилгээ нэг бүрийн төлбөрийн хэмжээ, үүнээс эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээ, хувь хүний төлсөн төлбөрийн хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.

3.7. Энэ журамд заасан төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогын зарцуулалтын жилийн эцсийн тайланг дараа жилийн төсвийн төсөлтэй хамт Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.8. Эмч, ажилчдыг төлбөртэй тусламж үйлчилгээ үзүүлж, орлого бүрдүүлсэн байдлаар гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтээр дүгнэн урамшуулал олгоно.

Дөрөв. Эмч, эмнэлгийн ажилтны хориглох зүйл

4.1. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний зардалд тухайн эмнэлэгт эмчлүүлэх үед хийгдсэн үндсэн оношилгоо, шинжилгээ, эм эмнэлгийн хэрэгсэл, материал, бариа засал, нөхөн сэргээх эмчилгээ, сувилахуйн тусламж үйлчилгээ багтах бөгөөд энэхүү зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас болон иргэнээс давхардуулан авахгүй. Даатгуулагчийн төлөх хамтын төлбөрийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын дагуу шийдвэрлэнэ.

4.2. Төлбөртэй өрөөнд хэвтэн эмчлүүлснээр үйлчлүүлэгч бусад төрлийн ижил тусламж үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчээс илүү эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, асаргаа, сувилгаа авах, хөнгөлөлт эдлэх үндэслэл болохгүй.

4.3. Энэхүү журмын хавсралтад заагдсан тусламж үйлчилгээний нэр төрөл, цар хүрээг өргөтгөх замаар үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого нэмэгдүүлэх эх үүсвэр болгохыг хориглоно.

4.4. Эмч, эмнэлгийн ажилтанд дараах зүйлсийг хориглоно:

4.4.1. Энэхүү тушаалын хавсралтад заасан төлбөрийн жишиг хэмжээнээс хэтэрсэн төлбөр нэхэмжлэхгүй байх;

4.4.2. Эрүүл мэндийн байгууллагын ажлын үндсэн цагт багтаан үзүүлэх боломжтой тусламж, үйлчилгээг ажлын бус цагаар эсвэл бусад хэлбэрээр тохиролцон төлбөртэй үзүүлэх;

4.4.3. Үйлчлүүлэгч төлбөрт үйлчилгээний орлогыг зөвхөн тус байгууллагын Төрийн сангийн 100 9000 200 12 тоот дансанд тушаана.

4.4.4 Төлбөртэй тусламж үйлчилгээний орлогыг бэлнээр авахыг хориглоно.

Тав. Хяналт

5.1. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх, байгууллагын үйл ажиллагааг доголдуулахгүй байх чиглэлээр төлбөрт үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүргийг Ерөнхий захирал, Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан дэд захирал нар хүлээнэ.

5.2. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлого, зарлагын гүйцэтгэл болон төлбөрт үйлчилгээний хэрэгжилтийн байдалд эрүүл мэндийн байгууллагын дотоод аудитын нэгж улирал бүр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дотоод аудитын нэгж жилд нэг удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргана.

5.3. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний талаарх иргэдийн өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн байдал, төлбөрт үйлчилгээний орлогын зарцуулалтын талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан дэд захирал болон тасаг, албадын дарга нар хангаж ажиллах ба эдгээр мэдээллийг ГССҮТ-ийн цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансанд байршуулсан байна. Үүнд:

5.3.1. Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ

5.3.2. Эрүүл мэндийн тухай хууль болон Эмнэлгийн тусламжийн тухай хуульд заасан төлбөрийг төр хариуцах үйлчилгээний төлбөрийн хэмжээ

5.3.3. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, оношийн бүлэг тус бүрээр эрүүл мэндийн даатгалаас олгож буй санхүүжилтийн хэмжээ, даатгуулагчийн хамтын төлбөрийн хэмжээ

Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.


6.2. Иргэн эрүүл мэндийн байгууллагын нэмэлт үйлчилгээтэй холбоотой асуудлаар тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагуудад гомдол гаргах эрхтэй.

6.3. Эрүүл мэндийн байгууллага энэхүү тушаалыг зөрчиж, төлбөр авсныг эрх бүхий этгээд нотолсон тохиолдолд эрүүл мэндийн байгууллага иргэний төлбөрийг буцаан олгож, хохирлыг барагдуулна.

6.4. Энэ журмын 6.3-т зааснаар иргэний төлбөрийг барагдуулсан бол Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд зааснаар буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Хөдөлмөрийн тухай хууль, дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлага ногдуулна.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн
Ерөнхий захирлын 2022 оны 11 сарын 29-ны
..... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

А/163



**ИРГЭН ӨӨРИЙН ХҮСЭЛТЭЭР ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ
ЗӨВШӨӨРЛИЙН МАЯГТ**

Үйлчлүүлэгч овогтой би өөрийн хүсэлтээр
..... тусламж үйлчилгээг төлбөртэйгээр авах хүсэлтэй байна.

(тусламж үйлчилгээний нэр)

Хүсэлт гаргасан: Гарын үсэг

/

Огноо он сар өдөр

**ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВӨӨС ИРГЭНД ҮЗҮҮЛЭХ
ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

д/д	№	Төлбөртэй тусламж үйлчилгээний нэр	Төлбөрийн хэмжээ /төгрөгөөр/
ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ			
Бичил амь судлалын шинжилгээ			
1	10101002	Мөөгөнцөр илрүүлэх	28,000
2	10101003	Бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ(шарх, хамар, хамар залгиур, залгиур, чих, нүд, умайн хүзүү, шээсний сув, үтрээ, өтгөн, идээ, буглаа, цэр, шээс, гуурсны арчдас(трахеостом, интубац, хэвлий, цээж, давсаг, ЭДВ-н болон бусад гуурс), хатгалтын шингэн, цэр, бронхийн угаадасны нян судлалын шинжилгээ(хэвлий, плевр, тархи, нугасны шингэн, үений шингэн, олгой цэс))	32,000
3	10101004	Нян тээгчийн шинжилгээ	30,000
4	10101005	Шинжлэгдэхүүнийг будаж, шинжлэх-Граммын будгийн арга	10,000
Биохимийн шинжилгээ			
5	10102003	АЛАТ	3,000
6	10102004	Альбумин	3,000
7	10102006	Амилаза	5,000
8	10102009	Антистрепитолизин O тест (ASLO/ASO) тоогоор	10,000
9	10102010	АСАТ	3,000
10	10102013	Билирубин нийт	8,000
11	10102014	Билирубин шууд	8,000
12	10102015	Билирубин шууд элэгний үйл ажиллагаа	3,000
13	10102018	ГТТ Гаммаглутамилтрансфераза	3,000
14	10102020	Глутамат дегидрогеназа-GLDH (Glutamate dehydrogenase)	5,000
15	10102021	Глюкоз	3,000
16	10102022	Глюкоз (нугасны шингэнд)	3,000
17	10102028	Кали	5,000
18	10102030	Кальци	4,000
19	10102033	Креатинин	4,000
20	10102039	Лактат	5,000
21	10102040	Лактат(нугасны ус)	4,000
22	10102043	ЛДГ	4,000
23	10102048	Магни	4,000
24	10102050	Микроальбумин	15,000
25	10102052	Мочевин	4,000
26	10102055	Натри	5,000
27	10102057	Нийт уураг	3,000
28	10102058	Нийт уураг(нугасны ус)	6,000
29	10102062	Нийт уураг (шээс)	6,000
30	10102063	Нойр булчирхайн амилаза (П амилаза)	6,000
31	10102064	Нугасны шингэнд хлор үзэх	5,000
32	10102066	Ревматоид фактор /RF/ (тоогоор)	9,000
33	10102067	С урвалжит уураг /CRP/ (тоогоор)	11,000
34	10102070	Төмөр	4,000
35	10102072	Триглицерид	3,000
36	10102075	Фосфор	3,000
37	10102079	Хлор	5,000
38	10102081	Холестерин	3,000
39	10102086	Шүлтлэг фосфотаза	4,000
40	10102091	Шээсний хүчил (цус)	3,000

41	10102093	Шээсэнд глюкоз тодорхойлох	5,000
Гетатологийн шинжилгээ			
42	10104005	УЭТХ (СОЭ)	4,500
43	10104008	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ	14,000
44	10105035	Кумбсын шууд урвалын шинжилгээ	14,000
45	10105038	Сөрөг Резус Д баталгаажуулах	7,000
46	10105043	Хуруу шил (хуруу шилний тоогоор үржүүлнэ)	20,000
47	10105044	Цусны бүлэг, резус	11,000
48	10105045	Цусны резус бүлэг тодорхойлох (Rh фактор), баталгаажуулах	6,000
49	10105046	Цусны хувийн тохироо тодорхойлох	15,000
Иммунологийн шинжилгээ			
50	10106107	Витамин Д нийт	40,000
51	10106116	ДОХ (HIV cassette)	6,000
52	10106150	Прокалцитонин (Procalcitonin)	85,000
53	10106169	Түрүү булчирхайн хавдрын маркер (PSA)	21,000
54	10106205	Хепатитын С вирусийн гадаргуугийн эсрэг биеийн үзүүлэлтийг тоолох аргаар үзэх (HBsAg quant) электрохимолюминесценц	60,000
Цус бүлэгнэлтийн шинжилгээ(коагулограмм)			
55	10109001	АРТТ	5,000
56	10109004	D-Dimer	60,000
57	10109005	Fibrinogen	6,000
58	10109012	ТТ	5,000
59	10109019	PT (INR)	5,000
Эмнэлзүйн химийн шинжилгээ			
60	10113017	Цусны хийн шинжилгээ	28,000
61	10113019	Шээсний ерөнхий шинжилгээ	6,000
Оношилгооны ажилбар, хэмжилт, сорил шинжилгээ			
Багажийн шинжилгээ			
62	10201005	Зүрхний цахилгаан бичлэг	9,000
Бүх төрлийн уян дурангийн оношилгоо			
63	10202001	Дурангийн хэт авиан оношилгоо(EUS)	550,000
64	10202002	Унтуулгатай уян дуран(Бүдүүн гэдэс, уушги, улаан хоолой, ходоод, төвөнх)	100,000
65	10202003	Уян дуран(Бүдүүн гэдэс, уушги, цлаан хоолой, ходоод, төвөнх)	70,000
66	10202004	Хатуу дуран (хамар, чих, арьс, вүүдийн ламп)	30,000
Бүх төрлийн хэт авиан оношилгоо			
67	10203001	Улаан хоолойн зүрхний хэт авиан шинжилгээ	50,000
68	10203002	Хэт авиа (зүрх, бамбай булчирхай, хөх, захын судас, нүд, хэвлий, нярайн түнх, нярайн зулай, цээж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрхтэн, гүрээний артери, зөөлөн эд, шөрмөс, үе тархины судасны доплер, тархины судасны дуплекс)	15,000
69	10203003	Хэт авиан хяналтанд хийх нарийн зүүний хатгалт, биопси (Бамбай, хөх, зөөлөн эд)	80,000
Бүх төрлийн компьютерт томографын оношилгоо			
70	10211001	Нэг байрлалд хийх тодосгогчгүй компьютерт томограф (Толгой, хамар, дайвар, ухархай, чамархай, хэвлий, бөөр, шээсний зам, цээж, зүрхний титэм судас, бага аарцаг, дээд мөч, доод мөч, хүзүү, сээр, ууц)	90,000
71	10211002	Нэг байрлалд хийх тодосгогчтой компьютерт томограф (Толгой, хамар, дайвар, ухархай, чамархай, хэвлий, бөөр, шээсний зам, цээж, зүрхний титэм судас, бага аарцаг, дээд мөч, доод мөч, хүзүү, сээр, ууц)	240,000
72	10211003	Олон байрлалд хийх тодосгогчгүй компьютерт томограф (Цээж хэвлий, бүтэн нуруу, политраума, толгой хүзүү)	120,000
73	10211004	Олон байрлалд хийх тодосгогчтой компьютерт томограф (Цээж хэвлий, бүтэн нуруу, политраума, толгой хүзүү)	270,000
Рентген оношилгоо			
74	10214002	Бүх төрлийн рентген оношилгоо 1 байрлал (Гавал, хамар, цээж, хүзүү, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч, аарцаг, аденойд, дал, өвчүү, ухархай, хавирга, чих, эгэм, эрүү)	10,000

75	10214003	Бүх төрлийн рентген оношилгоо 2 байрлал (Гавал, хамар, цээж, хүзүү, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч, аарцаг, аденойд, дал, өвчүү, ухархай, хавирга, чих, эгэм, эрүү)	20,000
76	10214006	Рентген харалт /Цээж, хэвлий/	10,000
77	10214007	Рентгений хяналтанд хийх ажилбар	60,000
78	10214009	Ясны сийрэгжилтийн шинжилгээ	33,000
Соронзон резонанст томограф (MRI)			
79	10215001	Тодосгогчгүй соронзон резонанст томограф (Тархи, хүзүү, сээр, бүсэлхий, ууц, зүрх, цээж, хөх, хэвлий, цөс-нойр булчирхай, бага аарцаг, мөр, тохой, сарвуу, дээд мөч, доод мөч, түнх, өвдөг, шагай)	350,000
80	10215002	Тодосгогчтой соронзон резонанст томограф (Тархи, хүзүү, сээр, бүсэлхий, ууц, зүрх, цээж, хөх, хэвлий, цөс-нойр булчирхай, бага аарцаг, мөр, тохой, сарвуу, дээд мөч, доод мөч, түнх, өвдөг, шагай)	500,000
Сэтгэл заслын тусламж үйлчилгээ			
81	10801001	Бүх төрлийн сэтгэл засал (Ганцаарчилсан, гэр бүлийн, хосын, өөрийгөө удирдах дасгал)	50,000
Сэтгэл зүйн оношилгоо, сорил			
82	10221001	Сэтгэл зүйн огошилгоо, сорил (Бүх төрлийн насанд хүрэгчдийн болон хүүхдийн сорилууд)	30,000
Сайн дурын дархлаажуулалт			
83	11001005	Галзуугийн эсрэг вакцин	10,000
Нэмэлт үйлчилгээ			
84	31401002	Захиалгат хоол	5,000-15,000
85	31401003	ЭМБ-ын тусгай хог хаягдал цуглуулах устгах (кг)	20,000
86	31401004	Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээ /люкс/	30,000-60,000
87	31401005	Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээ /хагас люкс/	10,000-30,000
Шарил хадгалах үйлчилгээ			
88	31402001	Шарил хадгалах үйлчилгээ /нэг хоногт, эмнэлгийн нас баралтаас бусад/	28,000
Шарил тээвэрлэх үйлчилгээ			
89	31402002	Шарил тээвэрлэх үйлчилгээ (1 км-т, яаралтай болон түргэн тусламжаас бусад тохиолдолд)	3,000
Захиалгат ариутгал			
90	31404001	Бикс, боодол (том, дунд, жижиг)	15,000
91	31404002	Дезкамер (матрас, гудас, хөнжил, дэр, гадар даавуу)	4,500
92	31405001	Ширхэгээр, дотуур хувцас	4,000
Өвчтөн тээвэрлэх			
93	31406001	Тоноглогдсон автомашин /эмч,сувилагчгүй/ Хөдөө орон нутагт	Цагт-10,000 + /шатахууны төлбөр 1 км-2000 төгрөг/
94	31406001	Тоноглогдсон автомашин /эмч,сувилагчгүй/ Улаанбаатар хот дотор 1 талдаа	50000 төгрөг
95	31406001	Тоноглогдсон автомашин /Эмч, сувилагчтай/	Цагт-20,000 /шатахууны төлбөр 1 км-1000 төгрөг/
96	31406001	Эмч	1 цаг- 10 000 төгрөг
97	31406001	Сувилагч	1 цаг – 8 000 төгрөг
98	31406001	Тэмцээн уралдаанд эмч, тоноглогдсон машинтай оролцох	1 өдөр 500,000


			/шатахууны төлбөр 1 км-1500 төгрөг/
99	31406001	Гадаад оронд үйлчлүүлэгчийг тээвэрлэн хүргэх, авч ирэх (1 км-т, яаралтай болон түргэн тусламжаас бусад тохиолдолд)	2,000
100	19901001	Зөвлөх эмчийн үзлэг, оношилгоо шинжилгээ	30,000
ЭМД-д хамрагдаагүй амбулаториор хийгдэх тусламж үйлчилгээ /бодит өртгөөр/			
101	19901001	Гэмтлийн дараах шинэ шархны боолт	5,000
102	19901001	5-10% талбайтай	5,000
103	19901001	10-15% талбайтай	8,000
103	19901001	15-20% талбайтай	10,000
104	19901001	25%-иас дээш талбайтай	15,000
105	19901001	Дээд мөчдийн гөлтгөнөн боолт	10,000
106	19901001	Доод мөчдийн гөлтгөнөн боолт	20,000
107	19901001	Гэмтлийн дараах /Хүндэрсэн/ шарх	10,000
108	19901001	Ясны идээт үрэвсэл /остеомиелит/	15,000
109	19901001	Холголт, цооролтын шарх	10,000
110	19901001	Гэмтлийн дараах хумсны хүндэрсэн шарх /авах ажилбар/	25,000
111	19901001	Хазагдсан шархууд /нохой, могой гэх мэт/	5,000
112	19901001	Цахилгаан гүйдлийн шархнууд	5,000
113	19901001	Нүүрний шарх цэгцлэх	50,000
114	19901001	Шанааны нум татах	50,000- 100,000
115	19901001	Хамрын шинэ гэмтэл /хамар ясны хугарал засах/	50,000- 100,000
116	19901001	Эрүүний ясны хугаралд чиг тавих ажилбар	50,000
Сувилахуйн тусламж үйлчилгээ			
117	19901001	Дуслаар тариа хийх	2,000
118	19901001	Судсанд тариа хийх	2,000
119	19901001	Булчинд тариа хийх	1,000
120	19901001	Арьсан дор тариа хийх	1,000
121	19901001	Сахуу татрангийн эсрэг вакцин	2,000
Эмчийн үзлэг			
122	19901001	Өвчний учир үзлэг, оношилгоо шинжилгээ	57,000
123	19901001	Өвчний учир үзлэг	15,000
Сэргээн засах эмчилгээ үйлчилгээ			
Тоног төхөөрөмж туслах хэрэгсэлтэй хөдөлгөөн засал эмчилгээ			
124	19901001	Дугуй	3,000
125	19901001	Гүйлтийн зам	3,000
126	19901001	Хүзүүний татлага	3,000
127	19901001	Параллель бар	2,000
Цахилгаан эмчилгээ болон гэрэл эмчилгээ			
128	19901001	УВЧ	3,000
129	19901001	Электрофороз	3,000
130	19901001	Искра	3,000
131	19901001	TENS /электронеуростимуляци/	3,000
132	19901001	EMS /электромиостимуляци/	3,000
133	19901001	Ультрозвук /Ultrasound/	4,000
134	19901001	УФО /гуурст кварц/	2,000
135	19901001	Кварц	2,000
136	19901001	Нірег500	10,000
137	19901001	Соллюкс	2,500

138	19901001	Лазер	5,000
139	19901001	Biowave	5,000
140	19901001	Импраруж	2,500
Хөдөлгөөн засал			
141	19901001	Амьсгал зүрх судасны тогтолцооны эмгэгүүд	10,000
142	19901001	Ортопед, гэмтлийн эмгэгүүд	10,000
143	19901001	Мэдрэлийн эмгэгүүд	15,000
144	19901001	Спортын гэмтлийн үеийн	10,000
145	19901001	Түлэнхийн дараах /13 наснаас дээш/	15,000
146	19901001	Түлэнхийн дараах /0-12 нас/	10,000
147	19901001	Хүүхдийн гэмтэл, согогийн эмгэгүүд	10,000
Иллэг, массаж /нэг удаагийн/			
148	19901001	Толгой, хүзүү	8,000
149	19901001	Нүүр	5,000
150	19901001	Цээж нуруу	10,000
151	19901001	Доод мөч	5,000
152	19901001	Дээд мөч	5,000
153	19901001	Хөлний ул	8,000
154	19901001	Бүтэн биеийн	15,000
Бусад			
155	19901001	Хөдөлмөр засал эмчилгээ	15,000
156	19901001	Хэл засал эмчилгээ	15,000
157	19901001	Парафин эмчилгээ	8,000
Уламжлалт эмчилгээ үйлчилгээ			
Бариа засал эмчилгээ			
158	19901001	Толгой хүзүү	10,000
159	19901001	Нүүрний саажилт	5,000
160	19901001	Сээр нуруу	5,000
161	19901001	Ууц нуруу	5,000
162	19901001	Дээд мөч	5,000
163	19901001	Доод мөч	5,000
164	19901001	Цэр ховхлох	5,000
165	19901001	Эмчилгээний тостой	8,000
166	19901001	Жамц давстай	8,000
167	19901001	Блок гаргах	3,000
Өвөрмөц бариа засал			
168	19901001	Параплеги	10,000
169	19901001	Гемиплеги	10,000
170	19901001	Тетраплеги	20,000
Бусад			
171	19901001	Зүү эмчилгээ	5,000
172	19901001	Бумба /гулгуур бумба, галт бумба/	3,000

173	19901001	Хануур	10,000
174	19901001	Төөнө засал	3,000
175	19901001	Шивүүр	8,000
176	19901001	Самнуур	8,000
177	19901001	Жин засал	2,500
178	19901001	Дэвтээлэг засал	8,000
Ажлын бус цагаар үзүүлэх амбулаторийн тусламж үйлчилгээ			
Амбулаторийн үзлэг			
179	300011	Өвчний учир үзлэг, оношилгоо шинжилгээ	<i>ЭМДҮЗ-ийн тогтоолын дагуу/ +20,000</i>
180	300012	Амбулаториор хийгдэх мэс ажилбар	<i>ЭМДҮЗ-ийн тогтоолын дагуу/ +20,000</i>
181	300013	Өвчний учир үзлэг	<i>ЭМДҮЗ-ийн тогтоолын дагуу/ +15,000</i>
182	350022	Сэргээн засахын амбулаторийн тусламж үйлчилгээ	<i>ЭМДҮЗ-ийн тогтоолын дагуу/ +20,000</i>
183	370025	Уламжлалт анагаах ухааны амбулаторийн тусламж үйлчилгээ	<i>ЭМДҮЗ-ийн тогтоолын дагуу/ +20,000</i>
Өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээ			
184	300031	MRI	<i>ЭМДҮЗ-ийн тогтоолын дагуу/ 105,000+150,000</i>
185	300032	Компьютер томографи оношилгоо	<i>ЭМДҮЗ-ийн тогтоолын дагуу/ 36,000+50,000</i>

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн
 Ерөнхий захирлын 2022 оны 11 сарын 29-ны
 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

А163



**ЭМЧИЛГЭЭНИЙ ТАСАГТ АЖИЛЛУУЛАХ ТӨЛБӨРТЭЙ ОРНЫ ТОО,
 ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

д/д	Тасаг, нэгжийн нэр	Палатны №		Орны тоо	Нэг орхоногийн төлбөр
1	Гар сарвуу нөхөн сэргээх бичил мэс заслын тасаг		Люкс		
		10,11	Хагас люкс	2	30000
2	Насанд хүрэгчдийн гэмтэл согогийн тасаг		Люкс		
		A11, Б-11,	Хагас люкс	2	30000
3	Түлэнхий нөхөн сэргээх мэс заслын тасаг		Люкс		
			Хагас люкс		
4	Хүүхдийн гэмтэл согогийн тасаг		Люкс		
		A-7,11 Б-7, 9,12	Хагас люкс	5	30000
5	Хэвтэн эмчлүүлэх амбулаторийн тасаг		Люкс		
		7	Хагас люкс	1	30000
6	Хүзүү, нурууны гэмтэл, согогийн тасаг		Люкс		
		8	Хагас люкс	1	30000
7	Хавсарсан гэмтлийн тасаг		Люкс		
		4	Хагас люкс	1	30000
8	Гавал тархины гэмтлийн тасаг	7,8,9	Люкс	3	40000
		10,11	Хагас люкс	4	30000
9	Эрчимт эмчилгээний тасаг		Люкс	1	40000
			Хагас люкс		
Нийт				19	